



МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙД,
САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2015 оны 3 сарын 16 өдөр

Дугаар 97 / 56

Улаанбаатар хот

Журам батлах, зардлын жишиг,
төлбөрийн хэмжээг тогтоох
тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дах хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 дах хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх журам”-ыг нэгдүгээр, “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын зардлын жишиг”-ийг хоёрдугаар, “Улсын төсвийн санхүүжилтээр төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтанд суралцагч эмнэлгийн мэргэжилтэнд тэтгэлэг олгох шалгуур, хувь хэмжээ”-г гуравдугаар, “Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн зэргийн шалгалтын багц, төлбөрийн хэмжээ”-г дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Улсын төсвийн зардлаар төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтанд суралцах эмнэлгийн мэргэжилтний тоог жил бүр тогтоож, журмын хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэнд, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Г.Ганчимэг/-д, төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын үйл ажиллагааг батлагдсан төсвийн хүрээнд зохион байгуулж, хэрэгжилтийг тус яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлд жил бүрийн 1 дүгээр сард багтаан танилцуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат-Эрдэнэ/-д тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэнд, спортын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Э.Оюунсүрэн/, Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдлийн удирдлагын газар /Б.Батцэцэг/-т тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2011 оны “Журам батлах, зардлын жишиг тогтоох тухай” 423/249 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Эрүүл мэнд, спортын сайд Сангийн
сайдын 2015 оны 3 сарын 16-ны
өдрийн 97/56 тоот хамтарсан
тушаалын нэгдүгээр хавсралт

Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон
давтан сургалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Эрүүл мэндийн салбарын төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтнийг (цаашид “суралцагч” гэх) улсын зардлаар төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт (цаашид “төгсөлтийн дараах сургалт” гэх)-нд хамруулахад энэхүү журмыг баримтлана.

1.2 Эрүүл мэнд, спортын яам (цаашид “ЭМСЯ” гэх)-ны харьяа Эрүүл мэндийн хөгжлийн төв (цаашид “ЭМХТ” гэх)-ийн Төгсөлтийн дараах сургалтын зохицуулалт хариуцсан нэгж (цаашид “ажлын алба” гэх) нь эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг улсын төсвөөс санхүүжүүлэхтэй холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

Хоёр. Сургалтын чиглэл, суралцагчийн тоог тогтоох

2.1 Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтанд хамруулах чиглэл, нийт суралцагчдын тоо болон улсын төсвийн зардлаар суралцагчдын тоог эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлого, хэрэгцээ, хүн амын эрүүл мэндийн байдал, эрүүл мэндийн байгууллагын захиалга, төгсөлтийн дараах сургалт явуулах байгууллагын хүчин чадал зэрэгтэй уялдуулан Эрүүл мэнд, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн жил бүр батална.

2.2 Ажлын алба нь эрүүл мэндийн салбарын төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудаас дараагийн жил үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн (цаашид “мэргэшлийн сургалт” гэх) сургалтанд суралцуулах чиглэл, эмнэлгийн мэргэжилтний тооны захиалгыг авч, зардлын тооцооны хамт 12 дугаар сарын 10-ны дотор ЭМСЯ-ны холбогдох нэгжид хүргүүлнэ.

2.3 ЭМСЯ-ны холбогдох нэгж нь ажлын албанаас ирүүлсэн мэргэшлийн сургалтын захиалга, зардлын тооцоог хянаж энэ журмын 2.1-т заасныг баримтлан мэргэшүүлэх сургалтанд хамруулах хяналтын тоонд багтаан улсын төсвөөр сургах төгсөлтийн дараах сургалтын мэргэшлийн чиглэл, элсэгчдийн хяналтын тоог жил бүрийн 2 дугаар сард багтаан Эрүүл мэнд, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулна.

2.4 Улсын төсвийн санхүүжилтээр зохион байгуулах эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах давтан сургалт (мэргэжил дээшлүүлэх болон багц цагийн)-ын чиглэлийг ЭМСЯ-ны холбогдох нэгж нь энэ журмын 2.1-т заасныг мөн адил баримтлан журмын 2.3-т дурдсан шийдвэртэй хамтатган жил бүрийн 2 дугаар сард багтаан батлуулна.

2.5 Ажлын алба нь дараа жилийн төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтын зардалд шаардагдах нийт төсвийн төслийг боловсруулж танилцуулгын хамт Төсвийн тухай хуульд заасан хугацааны дотор ЭМСЯ-ны холбогдох нэгжид ирүүлнэ.

2.6 ЭМСЯ-ны холбогдох нэгж нь Ажлын албанаас ирүүлсэн төсвийн төслийг хянаж, сайдын багцын төсөвт саналыг тусгана.

Гурав. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтанд хамрагдах нөхцөл, шаардлага

3.1 Төгсөлтийн дараах мэргэшлийн болон мэргэжил дээшлүүлэх сургалтанд суралцах эмнэлгийн мэргэжилтэн нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.1.1 “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт явуулах, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”-д заасан суралцагчдад тавигдах нийтлэг шаардлага;

3.1.2 хөдөө орон нутгаас суралцах эмнэлгийн мэргэжилтний хувьд Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 дах заалт;

3.1.3 төгсөлтийн дараах мэргэшлийн сургалтанд элсэгчдийн хувьд Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Төгсөлтийн дараах мэргэшлийн сургалтын элсэлт, төгсөлтийн шалгалтын журам”-д заасан элсэлтийн шалгалтанд тэнцсэн байх шалгуурыг тус тус хангасан байна.

3.2 Төгсөлтийн дараах мэргэшлийн болон мэргэжил дээшлүүлэх сургалтанд суралцах эмнэлгийн мэргэжилтэн нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Төгсөлтийн дараах мэргэшлийн сургалтын элсэлт, төгсөлтийн шалгалтын журам”-д заасан бичиг баримтаас гадна дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна. Үүнд:

3.2.1 Улсын төсвийн санхүүжилтээр суралцуулахаар тодорхойлсон харьяа Эрүүл мэндийн газар (цаашид ЭМГ гэх) болон эрүүл мэндийн байгууллагын албан бичиг (ЭМСЯ-ны харьяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн захиалгаар суралцах тохиолдолд тус байгууллагын албан бичиг).

3.3 Тухайн суралцагчийг эрүүл мэндийн байгууллага, орон нутгийн захиалгаар суралцаж байгааг нотлох харьяа аймаг, нийслэлийн ЭМГ-ын дарга, ЭМХТ-ийн захирлаар баталгаажуулсан суралцагчийн ЭМХТ, захиалагч эрүүл мэндийн байгууллагатай байгуулсан суралцах тухай гурвалсан гэрээг 5 хувь үйлдэж харьяа аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ, захиалагч эрүүл мэндийн байгууллага, суралцагч, ЭМХТ-д тус тус хадгална (ЭМСЯ-ны харьяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн захиалгаар суралцах тохиолдолд тус байгууллагатай байгуулсан гэрээг 3 хувь үйлдэж тухайн байгууллага, суралцагч, ЭМХТ-д тус тус хадгална).

3.4 Төгсөлтийн дараах мэргэшлийн болон мэргэжил дээшлүүлэх сургалтанд улсын төсвийн санхүүжилтээр суралцагч нь энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтанд заасан шалгуурыг хангасан тохиолдолд тэтгэлэг авах, үргэлжлүүлэн суралцах нөхцөл бүрдэнэ.

3.5 Журмын 3.3-т заасан гэрээний үлгэрчилсэн загварыг Ажлын алба, ЭМСЯ-ны холбогдох нэгж боловсруулж, ЭМСЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн баталгаажуулна.

Дөрөв. Сургалтын санхүүжилт, түүний зохион байгуулалт

4.1 Төгсөлтийн дараах сургалт явуулах зөвшөөрөл бүхий байгууллагын санхүүжилт

4.1.1 ЭМХТ нь төгсөлтийн дараах сургалт явуулах зөвшөөрөл бүхий байгууллагатай байгуулсан гэрээний дагуу сургалтын төлбөрийг олгоно.

4.1.2 Төгсөлтийн дараах сургалтыг явуулах зөвшөөрөл бүхий байгууллага нь сургалтын төлбөрийг зөвхөн сургалтын үйл ажиллагаанд дараах жишгийг баримтлан зарцуулна. Үүнд:

4.1.2.1 багшийн ажлын хөлсөнд 45%;

4.1.2.2 сургалтын материал (сургалтанд хэрэглэгдэх нэг удаагийн багаж, хэрэгсэл, зайлшгүй хэрэглэгдэх бусад материал, гарын авлага)-д 35%;

4.1.2.3 төгсөлтийн дараах сургалт явуулах байгууллагаас сургалтын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангахтай холбоотой зардалд 15%;

4.1.2.4 ЭМХТ-өөс төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, хэрэгжилтийг нэгдсэн зохион байгуулалтаар хангах, элсэлт, төгсөлтийн шалгалтыг зохион байгуулах, үнэмлэх, гэрчилгээг хэвлүүлэхтэй холбоотой зардалд 5%.

4.1.3 Сургалтын төлбөрийн багц цагийн ажлын хөлсний жишиг хэмжээг хавсралтад зааснаар тооцно.

4.2 Суралцагчид олгох тэтгэлэг, холбогдох бусад зардал

4.2.1 Төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн, мэргэжил дээшлүүлэх сургалтанд улсын төсвийн зардлаар суралцагчид олгох тэтгэлгийн хэмжээг хавсралтад зааснаар тооцож олгоно.

4.2.2 Улсын төсвийн санхүүжилтээр суралцагчдын нэрсийг баталсан шийдвэр, төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулж буй байгууллагаас тухайн суралцагчид тэтгэлэг олгох шалгуурыг хангасан тухай нотлох баримтуудыг үндэслэн энэхүү журмаар батлагдсан хувь хэмжээний дагуу тэтгэлэг олгох үйл ажиллагааг ЭМХТ-өөс сар бүрийн 25-ны дотор зохион байгуулна.

4.2.3 Гурван сараас дээш хугацааны төгсөлтийн дараах сургалтанд суралцагчдын 90 хүртэлх хоногийн албан тушаалын цалинг үндсэн байгууллага олгоно. Энэ хугацаанд тэтгэлэг давхцуулан олгохгүй.

4.2.4 Суралцагчийн сургалтанд анх ирэх, төгсөөд очих замын зардлыг захиалагч эрүүл мэндийн байгууллага нь хариуцна.

Тав. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит.

5.1 Ажлын алба нь төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулж буй байгууллагад олгосон сургалтын зардлын зарцуулалтанд тогтмол хяналт тавьж ажиллах бөгөөд ЭМСЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь төгсөлтийн дараах сургалтын зохион байгуулалт, санхүүжилттэй холбоотой үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон захиалгат хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийнэ.


5.2 Ажлын алба нь өмнөх жилийн төгсөлтийн дараах сургалтын санхүүжилтийн талаарх дэлгэрэнгүй тайланг жил бүрийн 1 дүгээр сард багтаан ЭМСЯ-ны хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан нэгжид ирүүлж, ЭМСЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөр мөн хугацаанд багтаан хэлэлцүүлнэ.

Зургаа. Бусад

6.1 Суралцагч нь төгсөлтийн дараах мэргэшлийн сургалтанд захиалгаар суралцаж төгссөний дараа тухайн гэрээ байгуулсан байгууллагад 5 ба түүнээс доошгүй жил, мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан бол 3 ба түүнээс доошгүй жил тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллана. Хэрэв суралцагч тухайн ажиллах гэрээг биелүүлээгүй тохиолдолд сургалтын төлбөр, тэтгэлэг зэрэг суралцагчтай холбоотой гарсан нийт зардлыг гэрээний дагуу нөхөн төлүүлнэ.

6.2 Ажлын алба нь улсын санхүүжилтээр төгсөлтийн дараах мэргэшлийн болон мэргэжил дээшлүүлэх сургалтанд суралцагсдын талаарх бүртгэлийг хөтлөн, суралцагчдын мэдээллийг байгуулсан гэрээний хүчинтэй хугацаанд буюу 3-5 жилийн хугацаанд цахим хуудсанд ил тод байршуулна.

6.3 Гэрээний хэрэгжилтийг талууд гэрээнд заасан хугацаанд дүгнэж гэрээтэй холбогдсон маргаантай асуудлыг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлүүлнэ.



Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн
сайдын 2015 оны 3 сарын 16-ны
өдрийн 97/56 тоот хамтарсан
тушаалын хоёрдугаар хавсралт

Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын зардлын жишиг

Хүснэгт 1. Төгсөлтийн дараах сургалтын төлбөр, тэтгэлгийн жишиг

№	Зардлын зүйл	Сургалтын төлбөр (1 багц цаг/төг)	Тэтгэлэг (хоногт/төг)
1	Үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн, мэргэжил дээшлүүлэх сургалт	16000	10000

Хүснэгт 2. Суралцагчдын шалгалт /элсэлт, төгсөлт, давтан/-ын төлбөрийн жишиг

№	Зардлын зүйл	Нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ (төг)
1	Үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн, мэргэжил дээшлүүлэх сургалт	Хүн	1	10000

Хүснэгт 3. Багшийн ажлын хөлсний төлбөрийн жишиг (багц цагийн болон зайн сургалт)

№	Зардлын зүйл	Нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ (төг)
1	Хичээлийн агуулга боловсруулах	нүүр	A4 хэмжээтэй, үсгийн фонт 11-12- той 1 хуудас	10000
2	Хичээл заах	цаг	1	Боловсролын болон Шинжлэх ухааны доктор - 20000 Бусад- 10000

Тайлбар: Сургалтын 1 цагийг 45 минутаар тооцно.

Хүснэгт 4. Багц цагийн сургалтын төлбөрийн жишиг

№	Сургалтанд хамрагдах мэргэжилтний тоо	1 багц цагийн төлбөр (төг)
1	60 хүртэл	12000
2	61-150	8000
3	151-ээс дээш	6000

Эрүүл мэнд, спортын сайд Сангийн
сайдын 2015 оны 3 сарын 16-ны
өдрийн 91/56 тоот хамтарсан
тушаалын гуравдугаар хавсралт

Улсын төсвийн санхүүжилтээр төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан
сургалтанд суралцагчид тэтгэлэг олгох шалгуур, хувь хэмжээ

Хүснэгт 5. Тэтгэлэг олгох шалгуур

№	Үзүүлэлт	Шалгуур	Нотлох баримт
I. Үндсэн мэргэшлийн сургалт			
1	Жижүүр эмчээр ажиллах*	Сард 1-ээс доошгүй удаа жижүүр эмчээр ажиллаж "А" үнэлгээ авсан байх	Сургалт явуулж буй байгууллагын Эмчилгээ эрхэлсэн дэд захирал/дэд даргын тодорхойлолт
2	Мэргэжлийн зөвлөлгөөн, хурал, эмгэг судлалын зөвлөлгөөн, байгууллагын эмч нарын хуралд илтгэл, мэдээлэл танилцуулах	Улиралд 1 удаа илтгэл, мэдээлэл тавьсан байх**	Сургалт явуулж буй байгууллагын Сургалт эрхэлсэн дэд захирал/дэд дарга (эсвэл түүнтэй адилтгах албан тушаалтан), хариуцсан багшийн тодорхойлолт
3	Үндсэн мэргэжлээр суралцагсаддаа англи хэл дээр илтгэл, мэдээлэл тавьж хэлэлцүүлэх	2 сард 1 удаа англи хэл дээр илтгэл, мэдээлэл тавьсан байх**	Сургалт явуулж буй байгууллагын Сургалт эрхэлсэн дэд захирал/дэд дарга (эсвэл түүнтэй адилтгах албан тушаалтан), хариуцсан багшийн тодорхойлолт
4	Сурлагын амжилт	Сурлагын үнэлгээ тойролтоор 80% ба түүнээс дээш байх**	Сургалт явуулж буй байгууллагын Сургалт эрхэлсэн дэд захирал/дэд дарга (эсвэл түүнтэй адилтгах албан тушаалтан), хариуцсан багшийн тодорхойлолт
5	Харилцаа хандлага, ёс зүй	Тухайн сард гомдол, санал, зөрчил гараагүй байх	Сургалт явуулж буй Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны даргын тодорхойлолт
6	Сургалтын ирц	Тухайн сард 100% (хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол харгалзан үзнэ)	Сургалт явуулж буй байгууллагын Сургалт эрхэлсэн дэд захирал/дэд дарга байгууллагын (эсвэл түүнтэй адилтгах албан тушаалтан), хариуцсан багшийн тодорхойлолт
7	Бусад: - Судалгааны ажилд оролцох - Мэдээлэл, сургалт, суртчилгаа хийхэд оролцох - Эмчилгээний болон үйл	Эдгээрийн аль нэг үйл ажиллагаанд тухайн сард идэвхитэй оролцсон байх	Сургалт явуулж буй байгууллагын холбогдох эрх бүхий албан тушаалтны тодорхойлолт

№	Үзүүлэлт	Шалгуур	Нотлох баримт
	ажиллагааны шинэ арга технологи санаачлахад оролцох - Оношилгоо эмчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамж боловсруулахад оролцох		
II. Төрөлжсөн мэргэшлийн сургалт (Дээд мэргэжилтэн)			
1	Мэргэжлийн зөвлөлгөөн, хурал, эмгэг судлалын зөвлөлгөөн, байгууллагын эмч нарын хуралд илтгэл, мэдээлэл танилцуулах	Улиралд 1 удаа илтгэл, мэдээлэл тавьсан байх**	Сургалт явуулж буй байгууллагын Сургалт эрхэлсэн дэд захирал/дэд дарга (эсвэл түүнтэй адилтгах албан тушаалтан), хариуцсан багшийн тодорхойлолт
2	Төрөлжсөн мэргэжлээр суралцагсаддаа англи хэл дээр илтгэл, мэдээлэл тавьж хэлэлцүүлэх	Суралцах хугацаандаа 2-оос доошгүй удаа англи хэл дээр илтгэл, мэдээлэл тавьсан байх**	Сургалт явуулж буй байгууллагын Сургалт эрхэлсэн дэд захирал/дэд дарга (эсвэл түүнтэй адилтгах албан тушаалтан), хариуцсан багшийн тодорхойлолт
3	Сурлагын амжилт	Сурлагын үнэлгээ улирлаар 85% ба түүнээс дээш байх**	Сургалт явуулж буй байгууллагын сургалт эрхэлсэн дэд захирал/дэд дарга (эсвэл түүнтэй адилтгах албан тушаалтан), хариуцсан багшийн тодорхойлолт
4	Харилцаа хандлага, ёс зүй	Тухайн сард гомдол, санал, зөрчил гараагүй байх	Сургалт явуулж буй байгууллагын Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны даргын тодорхойлолт
5	Сургалтын ирц	Тухайн сард 100% (хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол харгалзан үзнэ)	Сургалт явуулж буй байгууллагын ын Сургалт эрхэлсэн дэд захирал/дэд дарга (эсвэл түүнтэй адилтгах албан тушаалтан), хариуцсан багшийн тодорхойлолт
III. Төрөлжсөн мэргэшлийн сургалт (Сувилагч, бусад мэргэжилтэн)			
1	Мэргэжлийн зөвлөлгөөн, хурал, эмгэг судлалын зөвлөлгөөн, байгууллагын хуралд илтгэл, мэдээлэл танилцуулах	3 сард 1 удаа илтгэл, мэдээлэл тавьсан байх**	Сургалт явуулж буй байгууллагын Сургалт эрхэлсэн дэд захирал/дэд дарга (эсвэл түүнтэй адилтгах албан тушаалтан), хариуцсан багшийн тодорхойлолт
2	Төрөлжсөн мэргэжлээр суралцагсаддаа англи хэл дээр илтгэл, мэдээлэл тавьж хэлэлцүүлэх	Суралцах хугацаандаа 1-ээс доошгүй удаа англи хэл дээр илтгэл, мэдээлэл тавьсан байх**	Сургалт явуулж буй байгууллагын Сургалт эрхэлсэн дэд захирал/дэд дарга (эсвэл түүнтэй адилтгах албан тушаалтан), хариуцсан багшийн тодорхойлолт

№	Үзүүлэлт	Шалгуур	Нотлох баримт
3	Сурлагын амжилт	Сурлагын үнэлгээ улирлаар 80% ба түүнээс дээш байх**	Сургалт явуулж буй байгууллагын сургалт эрхэлсэн дэд захирал/дэд дарга (эсвэл түүнтэй адилтгах албан тушаалтан), хариуцсан багшийн тодорхойлолт
4	Харилцаа хандлага, ёс зүй	Тухайн сард гомдол, санал, зөрчил гараагүй байх	Сургалт явуулж буй байгууллагын Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны даргын тодорхойлолт
5	Сургалтын ирц	Тухайн сард 100% (хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол харгалзан үзнэ)	Сургалт эрхлэгч байгууллагын Сургалт эрхэлсэн дэд захирал/дэд дарга (эсвэл түүнтэй адилтгах албан тушаалтан), хариуцсан багшийн тодорхойлолт
IV. Мэргэжил дээшлүүлэх сургалт			
1	Мэргэжлийн зөвлөлгөөн, хурал, эмгэг судлалын зөвлөлгөөн, байгууллагын эмч нарын хуралд илтгэл, мэдээлэл танилцуулсан байх	Суралцах хугацаандаа 1 удаа илтгэл, мэдээлэл тавьсан байх**	Сургалт явуулж буй байгууллагын Сургалт эрхэлсэн дэд захирал/дэд дарга (эсвэл түүнтэй адилтгах албан тушаалтан), хариуцсан багшийн тодорхойлолт
2	Сурлагын амжилт	Төгсөлтийн шалгалтын үнэлгээ 80% ба түүнээс дээш байх (хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол харгалзан үзнэ)**	Сургалт явуулж буй байгууллагын Сургалт эрхэлсэн дэд захирал/дэд дарга (эсвэл түүнтэй адилтгах албан тушаалтан), хариуцсан багшийн тодорхойлолт
3	Харилцаа хандлага, ёс зүй	Тухайн сард гомдол, санал, зөрчил гараагүй байх	Сургалт явуулж буй байгууллагын Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны даргын тодорхойлолт
4	Сургалтын ирц	Тухайн сард 100% (хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол харгалзан үзнэ)	Сургалт явуулж буй байгууллагын Сургалт эрхэлсэн дэд захирал/дэд дарга (эсвэл түүнтэй адилтгах албан тушаалтан), хариуцсан багшийн тодорхойлолт

Тайлбар:*Жижүүр эмчээр ажиллах шаардлагагүй мэргэжлээр суралцагчид ногдох тэтгэлэгийн хувь хэмжээг Бусад (судалгааны ажил, мэдээлэл, сургалт, суртчилгаа хийх, эмчилгээний болон үйл ажиллагааны шинэ арга технологи санаачлах, оношилгоо эмчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамж боловсруулахад оролцох) шалгуурыг тооцон нэмж олгоно.

**2-3 сард болон суралцах хугацаандаа 1 удаа үнэлэгдэх шалгууруудыг хангасан бол хамрах бүх хугацааг оролцуулан ногдох тэтгэлэгийг хамрах хугацааны сүүлийн сард нэгтгэн олгоно.

Хүснэгт 6. Тэтгэлэг олгох хувь хэмжээ

Сургалтын төрөл	Тэтгэлгийн үзүүлэлт	Нийт тэтгэлэгийн хэмжээнээс тооцох хувь хэмжээ
Үндсэн мэргэшлийн сургалт	Сурлагын амжилт	20%
	Жижүүр эмчээр ажиллах	10%
	Мэргэжлийн зөвлөлгөөн, хурал, эмгэг судлалын зөвлөлгөөн, байгууллагын эмч нарын хуралд илтгэл, мэдээлэл танилцуулах	10%
	Үндсэн мэргэжлээр суралцагсаддаа англи хэл дээр илтгэл, мэдээлэл тавьж хэлэлцүүлэх	10%
	Сургалтын ирц	30%
	Харилцаа хандлага, ёс зүй	10%
	Бусад: - Судалгааны ажилд оролцох - Мэдээлэл, сургалт, суртчилгаа хийхэд оролцох - Эмчилгээний болон үйл ажиллагааны шинэ арга технологи санаачлахад оролцох - Оношилгоо эмчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамж боловсруулахад оролцох	10%
Төрөлжсөн мэргэшлийн сургалт	Мэргэжлийн зөвлөлгөөн, хурал, эмгэг судлалын зөвлөлгөөн, байгууллагын хуралд илтгэл, мэдээлэл танилцуулах	20%
	Төрөлжсөн мэргэжлээр суралцагсаддаа англи хэл дээр илтгэл, мэдээлэл тавьж хэлэлцүүлэх	10%
	Сурлагын амжилт	30%
	Харилцаа хандлага, ёс зүй	10%
	Сургалтын ирц	30%
Мэргэжил дээшлүүлэх сургалт	Мэргэжлийн зөвлөгөөн, хурал, эмгэг судлалын зөвлөгөөн, байгууллагын эмч нарын ярилцлагад илтгэл мэдээлэл танилцуулах	20%
	Сурлагын амжилт	40%
	Харилцаа хандлага, ёс зүй	10%
	Сургалтын ирц	30%


Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын 2015 оны 3-р сарын 16-ны өдрийн 92/56 тоот хамтарсан тушаалын дөрөвдүгээр хавсралт

Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн зэргийн шалгалтын багц, төлбөрийн хэмжээ

Хүснэгт 7. Мэргэжлийн зэргийн шалгалтын багц

I багц Өртөг өндөр эм,урвалж бодис хэрэглэдэг чиглэл	II багц Ажилбар ихтэй,тоног төхөөрөмж түлхүү хэрэглэдэг мэргэжлийн чиглэл	III багц Ажилбар багавтар тоног төхөөрөмж бага хэрэглэдэг мэргэжлийн чиглэл	IV багц Ажилбаргүй, ярилцлага, тохиолдол, бодлого хэрэглэдэг чиглэл
Нүүр амны мэс засал судлал	Эх барих, эмэгтэйчүүд судлал	Хавдар судлал	Дотор судлал
Нүүр амны согог засал судлал	Мэс засал судлал	Мэдээгүйжүүлэг судлал	Хүүхэд судлал
Нүүр амны гажиг засал судлал	Гэмтэл согог- засал судлал	Сэхээн амьдруулах- эрчимт эмчилгээ судлал	Мэдрэл судлал
Шүдний техникч	Чих хамар хоолой судлал	Яаралтай тусламж/ гамшгийн үеийн тусламж үйлчилгээ судлал	Халдварт өвчин судлал
	Нүд судлал	Уламжлалт анагаах ухаан судлал	Нийгмийн эрүүл мэнд судлал
	Анатомын эмгэг судлал	Зүү төөнө засал судлал	Сэтгэцийн эмгэг судлал
	Эмнэл зүйн эмгэг судлал	Сэргээн засал эмчилгээ судлал	Өрхийн анагаах ухаан судлал
	Шүүхийн анагаах ухаан судлал	Эмзүй судлал	
	Сувилахуйн төрөлжсөн чиглэлүүд	Арьс судлал	
		Дүрс оношилгоо судлал	
		Сувилахуй судлал	

Хүснэгт 8. Мэргэжлийн зэргийн шалгалтын төлбөрийн хэмжээ



Бүлэг	Мэргэжилтэн	Зэрэг	Төлбөр (төгрөг)
I багц	Их эмч, бусад дээд мэргэжилтэн	Ахлах/Тэргүүлэх/Зөвлөх	185000
	Бусад мэргэжилтэн	Ахлах/Тэргүүлэх	95000
II Багц	Их эмч,эм зүйч, бусад дээд мэргэжилтэн	Ахлах/Тэргүүлэх/Зөвлөх	165000
	Бусад мэргэжилтэн	Ахлах/Тэргүүлэх	85000
	Төрөлжсөн мэргэшлийн сувилагч	Ахлах/Тэргүүлэх/Зөвлөх	55000
	Их эмч,эм зүйч, бусад дээд мэргэжилтэн	Ахлах/Тэргүүлэх/Зөвлөх	145000
III багц	Бусад мэргэжилтэн	Ахлах/Тэргүүлэх	75000
	Сувилагч	Ахлах/Тэргүүлэх/Зөвлөх	45000
	Их эмч, бусад дээд мэргэжилтэн	Ахлах/Тэргүүлэх/Зөвлөх	125000
IV багц	Бусад мэргэжилтэн	Ахлах/Тэргүүлэх	65000